

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ

ХОРООНЫ ТОГТООЛ

2008 оны 7 дугаар
сарын 7-ны өдөр

Дугаар 171

Улаанбаатар хот

“Түшиг даатгал” ХХК-д ердийн даатгалын зарим
хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, Даатгалын тухай хуулийн 13.1.2, Хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.23 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Түшиг даатгал” ХХК-д даатгалын дараах хэлбэрээр ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нэмж олгосугай. Үүнд:

1/ Таримлын (1.2.12).

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-г, “Түшиг даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрийг нэмж бүртгэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН